



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/135/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn
Дорноговь аймаг
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn
Аудитор: Т.Мөнхтогтох
Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2020.02.13 № 1-6/63
танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД
СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН
ПРОКУРОРЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ЭНХБАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сум дахь Сум дундын Прокурорын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Замын-Үүд сум дахь Сум дундын Прокурорын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд сум дахь Сум дундын Прокурорын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Замын-Үүд сум дахь Сум дундын Прокурорын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.АРИУНАА



2.1. Оршил

Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сум дундын Ерөнхий прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Д.Энхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 29-ээс 2020 оны 01 дугаар сарын 30-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 86 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хуулийг дээдэлж, хүний эрх, эрх чөлөө, нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалахад оршино.

Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Прокурорын хяналтын ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэн хууль ёсыг чанд сахиулах, хүний эрх, эрх чөлөөг аливаа хэлбэрээр зөрчүүлэхгүй байх, дээд шатны прокурорын хяналтыг сайжруулах.
- Авлига, хүрээлэн байгаа орчны эсрэг, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан удирдан зохион байгуулах.
- Шүүхэд төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах оролцоо, үр дүнг нэмэгдүүлэх.
- Прокурорын хараат бус байдал хууль зүй, эдийн засаг, нийгэм, улс төрийн баталгааг ханган сайжруулах, сахилга, ёс зүй харьцааны соёл, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 277 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “aculous” программ хангамж ашигладаг байна.

Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 30 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн Нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 157,805.8 мянган төгрөгөөс тооцон 1,578.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 3,159.3 мянган төгрөгөөр тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,598.2 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	404.1	404.1
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	9,110.2	9,084.4	-25.8
Үндсэн хөрөнгө	956,419.3	949,442.8	-6,976.5
Нийт хөрөнгө	965,529.6	958,931.4	-6,598.2
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	965,529.6	958,931.4	-6,598.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	965,529.6	958,931.4	-6,598.2

Авлага дансны үлдэгдэл өссөн нь тус прокурорын газрын туслах ажилтан болон прокурорын шилжилт, томилгоотой холбоотойгоор цалингийн дансанд хэмнэлт үүсэж үлдэгдэл 404.1 мянган төгрөгийг нийгмийн даатгалын хэлтэс рүү шилжүүлэн авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 25.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 13,437.8 мянган төгрөгөөр өссөн бөгөөд үүний 9,937.8 мянган төгрөгийн хөрөнгийг Улсын Ерөнхий прокурорын газраас, 3,500.0 мянган төгрөгийн хөрөнгийг Сонгино хайрхан дүүргийн прокурорын газраас үнэ төлбөргүй авсан байна. 121,099.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн, акталсан хөрөнгө байхгүй байна.

Биет бус хөрөнгөд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 958.931.4 мянган төгрөг болж 6.598.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 3 зориулалтад 295,902.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 295,902.5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 295,902.5 мянган төгрөг буюу 100 хувьтай байна. /цалин хөлс болон нэмэгдэл урамшил 208,094.4 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 25,047.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 37,100.0 мянган төгрөг, хангамж бараа материал 14,120.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 4,700.0 мянган төгрөг, томилолт зочны зардал 1,500.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 4,060.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 380.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 900.0/

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 404.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 404.1 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 404.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 404.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. 2019 оны жилийн эцсийн нийгмийн даатгалын болон санхүүгийн байдлын тайлангаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 39 дүгээр зүйлийн 39.4.2 “өр, авлага үүсгэхгүй байх”, 45 дугаар зүйлийн 45.2 “төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 147 мэдээллийг хугацаанд нь, 0 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 0 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 629.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 130.7 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Түлш халаалт, цэвэр бохир усны зардлаас гүйлгэн зарцуулахдаа жинхэнэ зарлагаар тайлагнадаггүй байна.

Энэ нь (үнэн зөв байдал) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

Сарын мэдээ, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

1.3 Өгсөн зөвлөмж:

Түлш халаалт, цэвэр бохир усны төлбөрийг шилжүүлэхдээ нэхэмжлэхийн дүнгээр шилжүүлж байх. Аккрузл сууриар тайлан гаргах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,110,276.44</u>	<u>9,488,597.24</u>
33	АВЛАГА	00.00	404,191.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	404,191.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,110,276.44	9,084,406.24
354	Хангамжийн материал	9,110,276.44	9,084,406.24
35410	Бичиг хэргийн материал	1,583,447.00	1,677,831.80
35420	Аж ахуйн материал	6,629,279.44	7,117,759.94
35440	Түлш, шатах тослох материал	460,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	437,550.00	288,814.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>956,419,331.22</u>	<u>949,442,824.39</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	956,419,331.22	949,442,824.39
392	Биет хөрөнгө	947,344,331.22	940,367,824.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	926,350,460.00	926,350,460.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-00.11	-15,439,174.43
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,900,000.00	71,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-67,900,000.00	-67,900,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,435,275.67	28,856,959.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-15,490,345.20	-17,384,371.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,573,384.89	34,089,584.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,524,444.03	-19,605,634.52
393	Биет бус хөрөнгө	9,075,000.00	9,075,000.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,075,000.00	9,075,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>965,529,607.66</u>	<u>958,931,421.63</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>965,529,607.66</u>	<u>958,931,421.63</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	965,529,607.66	958,931,421.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	601,425,620.64	601,425,620.64
51101	Өмч: - төрийн	601,425,620.64	601,425,620.64
512	Хуримтлагдсан үр дүн	216,386,577.03	209,788,391.00
51210	Өмнөх үеийн үр дүн	216,386,577.03	216,386,577.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-6,598,186.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	147,717,409.99	147,717,409.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>965,529,607.66</u>	<u>958,931,421.63</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	313,036,275.00	309,340,384.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,273,875.00	13,437,884.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,273,875.00	13,437,884.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,273,875.00	13,437,884.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,273,875.00	13,437,884.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	311,762,400.00	295,902,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	311,762,400.00	295,902,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	311,762,400.00	295,902,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	326,332,372.53	315,938,570.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	326,332,372.53	315,938,570.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	320,906,472.53	315,038,570.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,255,365.54	206,647,781.00
210101	Үндсэн цалин	222,255,365.54	138,402,149.00
210102	Нэмэгдэл	00.00	61,352,106.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	6,893,526.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,313,257.88	26,089,828.00
210201	Тэтгэврийн даатгал	17,365,876.92	17,713,692.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,060,532.13	2,130,812.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,842,721.94	1,673,930.00
210204	Ажилгүйдлийн даатгал	541,636.91	418,482.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,502,489.98	4,152,912.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,869,616.00	37,100,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,362,458.00	1,273,975.00
210302	Түлш, халаалт	32,307,373.00	32,164,440.00
210303	Цэвэр, бохир ус	3,199,785.00	3,661,585.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,437,117.94	14,145,870.20
210401	Бичиг хэрэг	2,090,712.34	2,786,746.30
210402	Тээвэр, шатахуун	5,210,417.60	5,815,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,028,444.00	3,061,030.00
210404	Ном, хэвлэл	120,200.00	220,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	206,718.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,780,626.00	2,118,693.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	644,800.00	4,700,000.00
210604	Урсгал засвар	644,800.00	4,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,731,050.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	1,731,050.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	997,718.00	4,060,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	668,918.00	3,550,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	324,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	156,800.00	164,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,657,547.17	20,794,390.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,000.00	380,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,637,547.17	20,414,390.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,425,900.00	900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,425,900.00	900,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,425,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	900,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-13,296,097.53</u>	<u>-6,598,186.03</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-13,296,097.53</u>	<u>-6,598,186.03</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>311,762,400.00</u>	<u>295,902,500.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	311,762,400.00	295,902,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	311,762,400.00	295,902,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	311,762,400.00	295,902,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>311,762,400.00</u>	<u>295,902,500.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	311,762,400.00	295,902,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,336,500.00	295,002,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,976,200.00	208,094,400.00
210101	Үндсэн цалин	108,319,400.00	151,521,600.00
210102	Нэмэгдэл	104,562,000.00	50,198,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,094,800.00	6,374,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,697,100.00	25,047,400.00
210201	Тэтгэврийн даатгал	17,871,600.00	16,790,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,206,400.00	2,064,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,765,100.00	1,651,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	441,300.00	412,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,412,700.00	4,128,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,190,000.00	37,100,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,362,458.00	1,273,975.00
210302	Түлш, халаалт	32,627,757.00	31,718,216.00
210303	Цэвэр, бохир ус	3,199,785.00	4,107,809.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,174,400.00	14,120,000.00
210401	Бичиг хэрэг	4,542,000.00	3,096,250.00
210402	Тээвэр, шатахуун	4,887,471.00	5,496,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,227,805.00	3,061,030.00
210404	Ном, хэвлэл	135,200.00	220,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	206,718.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,175,206.00	2,101,820.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	4,700,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	4,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,550,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	1,550,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,948,800.00	4,060,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,620,000.00	3,550,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	324,000.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	156,800.00	164,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	380,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	380,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,425,900.00	900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,425,900.00	900,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,425,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	900,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	601,425,620.64	147,717,409.99	216,386,577.03	965,529,607.66
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	601,425,620.64	147,717,409.99	216,386,577.03	965,529,607.66
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	601,425,620.64	147,717,409.99	216,386,577.03	965,529,607.66
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,598,186.03	-6,598,186.03
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	601,425,620.64	147,717,409.99	209,788,391.00	958,931,421.63

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	295,902,500.00	295,902,500.00	00.00	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	295,902,500.00	295,902,500.00	00.00	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295,002,500.00	295,002,500.00	00.00	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,094,400.00	208,094,400.00	00.00	100.0
210101	Үндсэн цалин	151,521,600.00	151,521,600.00	00.00	100.0
210102	Нэмэгдэл	50,198,400.00	50,198,400.00	00.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,374,400.00	6,374,400.00	00.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,047,400.00	25,047,400.00	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	16,790,600.00	16,790,600.00	00.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,064,200.00	2,064,200.00	00.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,651,400.00	1,651,400.00	00.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	412,800.00	412,800.00	00.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,128,400.00	4,128,400.00	00.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,100,000.00	37,100,000.00	00.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	1,900,000.00	1,273,975.00	626,025.00	67.1
210302	Түлш, халаалт	31,700,000.00	31,718,216.00	-18,216.00	100.1
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	4,107,809.00	-607,809.00	117.4
2104	Хангамж, бараа материалын зардал	14,120,000.00	14,120,000.00	00.00	100.0
210401	Бичиг хэрэг	2,900,000.00	3,096,250.00	-196,250.00	106.8
210402	Тээвэр, шатахуун	5,300,000.00	5,496,500.00	-196,500.00	103.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,500,000.00	3,061,030.00	438,970.00	87.5
210404	Ном, хэвлэл	200,000.00	220,400.00	-20,400.00	110.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	144,000.00	-24,000.00	120.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,100,000.00	2,101,820.00	-1,820.00	100.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,700,000.00	4,700,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	4,700,000.00	4,700,000.00	00.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.0
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,060,700.00	4,060,700.00	00.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,550,000.00	3,550,000.00	00.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	164,700.00	164,700.00	00.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	00.00	100.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	380000.00	380000.00	00.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	380,000.00	380,000.00	00.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	900000.00	900000.00	00.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	900,000.00	00.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	900,000.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	295,902,500.00	295,902,500.00	00.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	295,902,500.00	295,902,500.00	00.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	295,902,500.00	295,902,500.00	00.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	14.00	14.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	00.00	100.0